



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/169/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ХАНБОГД СУМ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТСИЙН
ДАРГА Т.ЛХАГВА-ЭРДЭНЭ ТАНАА

2022.02.15 № 30

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

016020009

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	35.40	24.10
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	410.10	433.90
	Нийт хөрөнгийн дүн	445.50	458.00
	Нийт өр төлбөрийн дүн	0.50	0.60
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	445.00	457.40
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	445.50	458.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	384.80	308.30
	Үйл ажиллагааны зардлын дүн	281.80	295.90
	Үйл ажиллагааны үр дүн	103.00	12.40
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	103.00	12.40
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	445.00	445.00
	Тайлант оны үр дүн		12.40
	Эцсийн үлдэгдэл	445.00	457.40
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	308.90	292.10
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	276.90	280.10
	Үйл ажиллагааны ЦМГ	32.00	12.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	- 31.70	- 11.80
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.30	0.20
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.30
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.30	0.50
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	285.70	280.00
	Урсгал зардал	285.70	280.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	285.70	280.00
	Улсын төсвөөс санхүүжих	281.90	279.80
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	3.80	0.20

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх, хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах чиг үүрэгтэй 17 албан хаагчтай Өмнөговь аймгийн Ханбогд суманд үйл ажиллагаагаа явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал болон алслагдсан суманд очиж ажиллах санхүү төсөв, хүний нөөц, цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, бараа материал, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх аудитын цар хүрээ хязгаарлагдаж байсныг дурдах нь зүйтэй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллага нь орон тооны аж ахуйн нярав, эд хариуцагчгүйгээс ахлах нягтлан бодогч нь аж ахуй, нярвын ажлаа гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэл хөтлөлт, хяналтад эрсдэл үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 4 мэдээллийг хоцруулсан, 2021 оны хагас жилийн тайланг оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 66 ажил гүйлгээний 48,339.6 мянган төгрөгийн 6 нэр төрлийн худалдан авалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 11,071.0 мянган төгрөгийн дүн бүхий 2 ажил гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.6, 6.4.4, 6.4.5-д заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах чухал асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 61.8 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн 1 алдааг залруулж, дотоод хяналт, бүртгэл сайжруулах 1 албан шаардлага хүргүүлж, 60.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	5	2.4	1	0.9			1	0	3	1.5
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	59.4							1	59.4
3	Нийт дүн	6	61.8	1	0.9			1	0	4	60.9